



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

┌ Удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах
зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс хавсралтад дурдсан нэр бүхий гишүүдийг чөлөөлсүгэй.

2. Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд шинээр томилогдох гишүүдийг холбогдох хууль, журмын дагуу хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж, Хуралд өргөн барьж хэлэлцүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Б.Мягмар)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100531

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 03 сарын 30-ний өдрийн 24 дүгээр
тогтоолын хавсралт



ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БОЛОН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ ГИШҮҮДИЙН НЭРС

Д/д	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэр	Чөлөөлөгдөх гишүүний нэр
1	Нийслэлийн Орон сууцны корпораци ХК	Д.Сумъяабазар
2	"Гэрлэх ёслолын ордон" ОНӨААТҮГ	З.Төмөртөмөө
3	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ	Д.Ганболд
4	"Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар" ОНӨААТҮГ	
5	"Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК	Т.Оюунчимэг
6	"Олон улсын худалдаа логистик" ХХК	
7	"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ	М.Баяраа
8	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ	
9	"Нийслэлийн Орон сууцны корпораци" ХК	
10	"Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ	Б.Мөнгөншагай
11	"Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт" ХХК	М.Аясгалан
12	"Олон улсын худалдаа логистикийн төв" ХК	Б.Одсүрэн
13	"Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК" ХК	
14	"Улаанбаатар смарт карт" ХХК	
15	"Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ	
16	"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ	Н.Мөнхбаатар
17	"Олон улсын худалдаа логистик" ХХК	Б.Болор-Эрдэнэ
18	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ	Ш.Үнэнбат
19	"Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" ОНӨТҮГ	Д.Баянбат
20	"Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК	Д.Итгэл
21	"Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ	
22	"Геодези усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ	С.Сэржжаргал
23	"Улаанбаатар спорт менежмент" ХК	Б.Батбаяр
24	"Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК	Б.Хаш-Эрдэнэ
25	"Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК	Н.Баярчимэг
26	"Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК	Н.Мандуул
27	"Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ	Л.Одхүү